



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар A/38

Жаргалант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн баярын өдрөөр зохион байгуулах шилдэг 9 алдартан, марш тактикийн тэмцээний зардал 2562000 (хоёр сая таван зуун жаран хоёр мянга) төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулсугай.

2. "Цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, цэргийн албыг сурталчлан таниулах, эрүүл амьдралын дадал хэвшил" сургалт зохион байгуулах лектор багшид 700,000 (долоон зуун мянга) төгрөг, цэргийн ангийн дуучдад 600,00 (зургаан зуун мянга) төгрөг, нийт 1300000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

3. Цэргийн баяраар зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардлыг холбогдох зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө ДАВААЖАРГАЛ

232501092



Сумын Засаг даргын 2025 оны 03
дугаар сарын 18-ны өдрийн А/38
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Зардлын нэр	Нийт үнэ (төгрөг)
Засаг даргын нөөц хөрөнгөнөөс		
1	Шилдэг 9 эрчүүдийн шагнал	621,000
2	Витамины үнэ	576,000
3	Өргөмжлөл, медаль	225,000
4	Хулдаасан хэвлэл	240,000
5	Хийн гар буу	150,000
6	Марш тактикийн тэмцээний шагнал	750,000
	Дүн	2,562,000
Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардал		
1	Летор багшийн хөлс	700,000
2	Цэргийн ангийн дуучдын хөлс	600,000
	дүн	1,300,000